



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/348

Ховд

Мөнгөн урамшуулал олгох тухай

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын 2.10 дугаар заалт, Төрийн аудитын газрын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сум, байгууллагын 2020 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангахад амжилт гаргаж нэгдсэн тайлан болон харъяа байгууллагууд нь аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажиллаж байсан Буянт сумын Засаг дарга М.Пүрэв, Ховд сумын Засаг дарга Ш.Ерболат нарыг нэг сарын албан тушаалын цалингийн 40.0 хувиар тооцож тус тус мөнгөн урамшуулал олгосугай.

2. Ховд сумын Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн төлөөлөгч нарыг үндсэн цалингийн 30.0 хувиар тооцож мөнгөн урамшуулал олгохыг тус сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Тус захирамжийн хэрэгжилтийг хангаж мөнгөн урамшууллыг 2021 оны батлагдсан цалингийн санд багтаан олгохыг төсвийн захирагчдад үүрэг болгосугай.

4. Тус захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

DZah-A/348-Bo